



“НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ” УТУГ  
ДАРГЫН ТУШААЛ

02.05 оны 01 сарын 09 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, 61.1.2, 61.1.5, 61.1.7 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргачийн 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-ын дүрэм"-ийн 2.8, Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын “Албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар 2025-2026 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, жил бурийн төсөвт тусган, жилийн эцест тайлганахыг Санхүү, төлөвлөлтийн хэлтэс (Б.Үүрцайх)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтэс (М.Болормаа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн A/03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Э.БОЛОР-ЭРДЭНЭ



Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ЫН  
даргын 2025 оны .... дүгээр сарын 09. ны  
өдрийн 8:05.. дугаар тушаалын хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ-ЫН АЛБАН  
ХААГЧДЫГ СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ, НИЙГМИЙН  
БАТАЛГААГ ХАНГАХ ТАЛААР 2025-2026 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР**

**Нэг. Ерөнхий үндэслэл**

Монгол улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хуулийн суурь зарчим (мерит) чадахуйн болон шатлан дэвших зарчим, тухайн хуулийг дагалдаж мөрдөхөөр гарсан журам, Засгийн газрын, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, зөвлөмж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үйл ажиллагааны Гүйцэтгэлийн гэрээний зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор (цаашид “Хөтөлбөр” гэх) энэхүү хөтөлбөрийг 2025-2026 онд хэрэгжүүлж ажиллана.

Хөтөлбөрийн зорилго нь Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ЫН ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, үнэнч шударга, идэвх санаачилгатай ажиллаж амьдрах, сурч, хөгжих, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хөтөлбөр нь “Албан хаагчдын сургалт хөгжил”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

**Хөтөлбөрийн зорилтууд нь :**

-Төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлж, хөгжүүлснээр төрийн үйлчилгээний байгууллагын шинэчлэлийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

-Төрийн үйлчилгээний албан хаагчдыг мэргэшүүлж тогтвортой, суурьшилтай ажиллуулна.

-Төрийн албан хаагч нь үр бүтээлтэй, санаачилгатай ажиллаж, мэдлэг мэдээлэл олж авах, онол арга зүй, үр чадвар сайжирна.

-Албан хаагчдын манлайлал, үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг хангахад чиглэнэ.

**Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа :**

-Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ЫН албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангахад зориулсан санхүүжилтийг жил бүр төсөвт тусган хэрэгжүүлнэ.

-Нөөц бололцоо бусад санхүүгийн хандив, тусламж, эх үүсвэрийг хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд ашиглаж болно.

-Хөтөлбөрийг 2025-2026 онд хэрэгжүүлнэ.

**Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх :**

**2.1 “Албан хаагчдын сургалт, хөгжил”**

Ажилтан, албан хаагчдын мэргэжлийн үр чадвар, мэдлэгийг байнга тасралтгүй дээшлүүлэх, ажил хариуцах чадварыг сайжруулах замаар үйл

ажиллагааны чадавх, гүйцэтгэл сайтай төрийн үйлчилгээний албыг бурдүүлж, суралцагч байгууллага болох зорилгоор сургалтыг дараах үе шаттайгаар явуулна.

2.1.1. Төрийн албан хаагчийг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах “Сургалтын төлөвлөгөө” боловсруулж, батлуулж мөрдөх

2.1.2. Төрийн албан хаагчийг сургаж, хөгжүүлэхдээ төрийн албан тушаалын ангилалд нийцүүлэн мэргэшүүлж бэлтгэх, харин тодорхой албан тушаалд томилогдсон албан хаагчийг тухайн албан тушаалын чиг үүрэг, онцлогт нийцүүлэн богино хугацааны зорилтот сургалтад хамруулан бэлтгэх

2.1.3. Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтыг албан тушаал дэвшүүлэх, цалинг нэмэгдүүлэх зэрэг урамшууллын тогтолцоотой нягт уялдуулах

2.1.4. Мэдлэг чадвар, харьцаа хандлага, ёс зүйн сургалтыг тухай бүр зохион байгуулах

2.1.5. Төрийн албаны манлайлах чадварын сургалтыг зохион байгуулах

2.1.6. Албан хаагчдыг монгол хэл бичиг, төрийн байгууллагын албан хэрэг хөтөллтийн (онлайн) сургалтад хамруулж, чадавхжуулах.

2.1.7. Албан хаагчдыг сүүлийн үеийн компьютерын программууд дээр сурч, ажиллах (онлайн) сургалтыг зохион байгуулах.

2.1.8. Төсвийн шууд захирагч болон менежерийн төрийн албаны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад тухай бүр хамруулж тасралтгүй байдлыг хангах.

2.1.9. Сургалт нь дотоод, гадаад, ажлын байранд гэсэн хэлбэртэй байх ба гадаадын сургалт англи болон бусад хэлний сургалтад албан хаагчдыг хамруулах бололцоог олгоно.

2.1.10. Сургалтын хөтөлбөр хэрэгжсэнээр төрийн албан хаагч нь сурч боловсorch мэдлэг, чадвартай болж байгууллагын албан хаагчдыг мэргэжил, мэргэшил, мөнөжер, магистр болон бусад шатны сургалтад хамруулахыг дэмжиж өргөн хүрээтэй хөгжүүлэн, өндөр соёл, ухамсартай ажиллаж, амьдрахад нь зайлшгүй чухал хэрэгцээтэй байх болно.

## **2.2.“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах”**

Албан хаагчдын үйл ажиллагааны баталгаа, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахдаа:

2.2.1. Албан хаагчийн цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, нийгмийн баталгааг дордуулахгүй, өнөөгийн хүрсэн түвшнээс бууруулахгүй байх зарчим баримтлах

2.2.2. Албан хаагчийн үндсэн цалинг тогтоохдоо тухайн төрийн албан тушаалыг эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар, хүлээх хариуцлага, ажлын ачаалал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэргийг харгалзаж, адил үнэлэмж бүхий ажилд адил хэмжээний хөлс олгох зарчмыг баримталж, бодитой шударга тогтоох

2.2.3. Албан хаагчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг бодитой үнэлж тогтоох арга зүйг боловсронгуй болгох, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил, үүргийн хүрээнд гүйцэтгэлийг үнэлэх замаар шатлан дэвших нөхцөлийг бурдүүлэх, төрийн үйлчилгээний байгууллагын түвшинд үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгод нийцүүлэх

2.2.4. Тусламж, орон сууц, гэр хүссэн, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар өргөдөл гаргасан албан хаагчдын асуудлыг хөнгөлөлттэй зээлд хамруулах, хөнгөлөлт олгох, холбогдох дээд газарт уламжлах журмаар шийдвэрлэх

2.2.5. Албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн хэмжээг ажилласан хугацаатай уялдуулж, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах зорилгоор төрийн албан хаагчийг тэтгэвэр тогтоолгооос өмнө тасралтгүй 5-аас доошгүй жил ажилласан байх нөхцөл, шалгуурыг тогтооно.

2.2.6 Өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдад тэтгэвэрт гарахад нь хуульд заасан хугацааны цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох

2.2.7. Албан хаагчдын эрүүл мэнд чийрэгжилтэд анхаарч, амралт-чийрэгжүүлэлтийн өрөөг тохижуулах, Нийслэлийн харьяа байгууллагууд болон Төрийн тусгайллах чиг үүрэг бүхий үйлчилгээний авто баазуудын спортын уралдаан тэмцээн, спорт явган аялал зохиох зэрэг ажлуудыг зохион байгуулж, гадаад, дотоодын төрөл бүрийн хэлбэртэй аялал, жуулчлалыг бүрэн дэмжинэ.

### **Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх үе шат :**

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн бүрэн эрхийн хугацаанд Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын бизнес төлөвлөгөөтэй уялдуулж, хөтөлбөрийг жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэх ба байгууллагын нийт албан хаагчид мэдлэг боловсрол, ур чадвар, зан харьцаа, хандлага, ёс зүй соёлоороо манлайллагч байж хэрэглэгчдэд төрийн үйлчилгээг бодитойгоор хүргэж, тэдний өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай гүйцэтгэснээр хөтөлбөрт тусгагдсан зорилтууд бүрэн хэрэгжих болно.

Энэхүү хөтөлбөрт тусгагдсан зорилтууд нь байгууллагын албан хаагчдын сурч мэргэших, хөгжих, амьдрах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн тул байгууллагын хүчин чадлын бололцоотой нөөцийг дайчилна.

### **Дөрөв. Хүрэх үр дүн**

Хөтөлбөр нь албан хаагчдын идэвх оролцоо, мэдлэг чадвар, санаачилга, ажлын үр дүнгээс хамааралтай байж амжилттай хэрэгжиж үр дүнд хүрнэ.

Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн чадавх сайтай, тасралтгүй суралцаж, хөгжиж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн үр дүнд чиглэсэн төрийн үйлчилгээний бүтээмж, чанарын өндөр түвшинд хүрсэн хамт олон бүрдэж, гадаад, дотоодын мэргэшлийн сургалтад албан хаагчид үе шаттай хамрагдсанаар байгууллага нь төрийн үйлчилгээ, удирдлагаар дээд түвшинд мэргэшсэн магистрын зэрэг цолтой албан хаагчдын тоо нэмэгдэж, нийгмийн баталгаа одоогийн байдлаас дээшилсэн байх болно.

**Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх  
нийгмийн баталгааг хангах (2025-2026 онд) хөтөлбөрт  
тусгагдсан ажлын зардлын төсөв**

2025 оны 01 дүгээр сарын 09

**Нэг. Сургалт ба мэдлэг чадвар бий болгох талаар:**

№	Хэрэгжүүлэх ажил, зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв, санхүүжилт (төгрөг)
1.1	Байгууллагын удирдах албан тушаалтан болон нарийн мэргэжлийн албан тушаал дээр ажиллаж байгаа ажилтныг мэргэшүүлэх, туршлага судлах, гадаад, дотоодын сургалтад (засварчин) хамруулах	НЭДТГ яам, дээд газруудаас ирүүлсэн саналын дагуу дотоодын нарийн мэргэжил, мэргэшил зээмшүүлэх урт богино хэлний сургалтад тавигдсан шаардлагыг хангаж буй албан хаагчдыг бүрэн дэмжиж сургалтад хамруулна.	Сургалтад 1 сая төгрөг
1.2	Байгууллагын удирдлага, захиргаа, санхүү, инженер, удирдах албан хаагчдыг сургах	Байгууллагын стратеги, зорилгыг тодорхойлох хөгжүүлэх, бодлогын баримт бичгийг шинэчлэх, гүйцэтгэлийн болон бизнес төлөвлөгөөг оновчтой төлөвлөх арга барил эзэмших талаар сургалтад хамруулна.	НЭДТГ сургалт -
1.3	"Мэдээллийн болон харьцаа, соёлын мэдлэг олгох цаг"-ийг тодорхой чиглэл зорилготой төлөвлөгөөтэй зохион байгуулах.	1.Жил бүрийн төлөвлөгөөнд тусгасны дагуу жолооч нарт шинэчилсэн Замын хөдөлгөөний дүрэм, Гамшигийн болон галын аюулгүй байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гарсан бусад хууль, тогтоомж, дүрэм, журмуудаар сургалт зохион байгуулах. 2.Нийт албан хаагчдад төрийн албан хаагчдын ёс зүй, үйлчилгээний соёл, харьцаа хандлагын талаар холбогдох байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах.	Лекц яриа хийсэн багшид нэг цагийн 50,0 төгрөг  жилд 1-2 удаа  жилдээ 100,0 төгрөг
1.4	Төрийн байгууллагын албан хэрэг хетлэлт, компьютерын хэрэглээний программын сургалт	1.Төрийн байгууллагын албан хэрэг хетлэлт, компьютерын хэрэглээний программ хангамж, нийслэлийн Нэгдсэн системийн талаарх сургалтад захиргаа, санхүү, инженер техникч, диспетчер-механикуудыг хамруулах.	НЭДТГ, НАГ, ЗХҮТ, Хүний нөөцийн хөгжлийн төв -

**Хоёр. Ажиллаж, амьдрах нөхцөл бололцоо нийгмийн асуудлын талаар**

№	Хэрэгжүүлэх ажил, зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв, санхүүжилт (төгрөг)
2.1	Нийгмийн баталгааг хангах талаар	1.Байгууллагаас тусламж орон сууц, гэр нийгмийн асуудал, тэтгэмж хүссэн албан хаагчдыг өргөдөл, хүсэлт өгсөн хугацаагаар нь дараалалд оруулан орон сууцны хөнгөлөлт, бусад хөнгөлөлттэй	Төсөвт тусган хэрэгжүүлнэ.  Жилд 20,0 сая

		зээлд хамруулах, туслалцаа үзүүлэхдээ тус байгууллагад 5-аас дээш жил ажилласан байх, ажлын үр дүн, үнэлгээ идэвх санаачилга, амьдралын нөхцөл байдал, орон сууцгүй зэргийг харгалзан олгох асуудлыг хамт олны хурлаар шийдвэрлэнэ.	төгрөг.
2.2	Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэн нийслэлийн нэгдсэн цахим систем, программ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын шаардлага хангасан хэрэгслээр хангана.	1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сан <a href="http://www.erp.ulaaanbaatar.mn">www.erp.ulaaanbaatar.mn</a> , цахим хуудсыг бүрэн ашиглаж, мэдээлэл солилцох ажлыг хэвшүүлэх 2.Санхүүгийн “Ноён”, “Авто” программуудыг шинэчлэх 3.Ажилтнуудыг сүүлийн үеийн хүчин чадал бүхий компьютер, принтер, диктафон, сканераар хангах, санхүү, архив, албан хэрэг хөтлөлт, бусад ажлын шинэчилсэн программууд авах тэдэнд зааж, сургах ажлыг зохион байгуулна.	жилд 5 сая төгрөг
2.3	Дотоод сүлжээ, вэбсайт, интернэт, камерын ашиглалт	Байгууллагын дотоод сүлжээ, вэбсайтыг шинэчилж, бүрэн дүүрэн ашиглах, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, байгууллагын мэдээ мэдээлэл, бодлогын шийдвэр хэрэгжилтийг ил тод байдлаар вэбсайтад тавьж үргэлжлүүлэн хийнэ.	жилд 1,0 сая төгрөг
2.4	Цалин хөлс, шагнал, урамшуулалт	1.Ажлын гүйцэтгэл, үнэлгээгээр бусдыгаа манлайлан тэргүүлсэн албан хаагчдыг хагас жил, жилийн эцсээр тэмдэглэлт ойн баяруудаар шагнаж урамшуулах, дээд газрын шагналд тодорхойлох, албан тушаалд шатлан дэвших нөхцөлийг бурдуулэх, терийн үйлчилгээний байгууллага, албан хаагчийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгод нийцуулнэ.	Газрын даргын тушаал шийдвэр, хөдөлмөрийн дотоод журмын дагуу хагас жил, жилийн эцсийн шагналт цалинг олгоно.
2.5	Эрүүл мэнд	1.Жил бүр албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр оруулж, шинжилгээ хийлгэн эрүүл мэндэд нь анхаарах, тамхи болон хорт зуршилаас урьдчилан сэргийлэх талаар ажил зохионо.  2.Албан хаагчдыг дархлаажуулалтын вакцин, бусад шинжилгээнд хамруулах	ХТХ-н 92.1, 92.2 дахь заалтыг үндэслэн үзлэгийн зардлыг байгууллагаас олгоно.  8 сая төгрөг хүртэл
2.6	Биеийн тамир, спорт	1.Байгууллагын албан хаагчдыг чөлөөт цагаар нь спортоор хичээллүүлж, хуваарийн дагуу зааланд тоглуулах бусад арга хэмжээнд оролцох боломж бурдуулэх, спортын 5 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, багуудыг идэвхтэй оролцуулж, багийг спортын хувцастай болгоно.	Байгууллагын даргын шийдвэрээр санхүүгийн асуудлыг шийдвэрлэх .

	<p>2. Нийслэлийн байгууллагууд болон төрийн үйлчилгээний баазуудын биеийн тамир спортын хороо, холбоодтой хамтран ажиллана.</p> <p>3. Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөл, бригадуудтай хамтран өвөл, зуны улиралд хамт олноороо цэвэр агаарт гарах ажлыг зохион байгуулна.</p>	жилд 6 сая төгрөг хүртэл
		жилд 42 сая төгрөг хүртэл

#### НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ-ЫН ЗАХИРГАА